



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

9
АНГИ

ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

ЭРЭГТЭЙ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:


Сурагчийн нэр:

Сурагчийн код:


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад хийж гүйцэтгээрэй.
- Зөв гэж үзсэн нэг хариуг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.


1. Дараах деталийг огтлогч хавтгайгаар огтлоход үүссэн дүрсийг ямар аргаар зурсан бэ?



2. Дараах деталиудын аль нь давхцуулсан огтлолын дүрслэл вэ? Зөв хариуг сонгоно уу.



3. Хэвтээ проекцлогч зүсэлтийн хавтгайг сонгоно уу.




4. Дараах зүсэлтийн дүрслэлийг сайтар ажиглаад, тайлбартай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1		a	Хэрэв зүсэлт хийсэн биетийн гадна талын үндсэн зураас нь тэгш хэмийн тэнхлэгтэй давхцаж байвал байдлыг илүү дүрсэлж, долгионтой зураасаар заагладаг.
2		b	Биетийн хязгаарлагдмал хэсэгт хэсэгчилсэн зүсэлт хийж, долгионтой зураасаар хязгаарладаг.
3		c	Бие тэгш хэмтэй үед байдал болон зүсэлтийг цэгтэй тасархай нарийн зураасаар зааглаж байдлыг зүүн хагаст, зүсэлтийг баруун хагаст үзүүлдэг.

A. 1-b, 2-c, 3-a B. 1-a, 2-c, 3-b C. 1-a, 2-b, 3-c D. 1-c, 2-b, 3-a

5. Модон материалын огтлолд орсон дүрслэлийн тэмдэглэгээг сонгоно уу.



6. Логонуудыг ажиглаад, тайлбартай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.


1		a	Үсэг ба дүрсээр бүрдсэн тэмдэг
2		b	Дүрсээр бүтсэн тэмдэг
3		c	Үсэг үгнээс бүрдсэн тэмдэг

A. 1-с, 2-b, 3-a B. 1-a, 2-с, 3-b C. 1-a, 2-b, 3-с D. 1-b, 2-a, 3-с

7. Сийлбэр хийхдээ модон материалын ямар шинж чанарыг голлож анхаарах вэ?


A. нягт B. хүнд C. үнэртэй D. хөнгөн

8. Сийлбэрийн технологи үйл ажиллагааны үед бөөрөнхий хэлбэртэй гадаргуу үүсгэж ухах үйлдэл хийдэг хутгыг зурагт үзүүлжээ. Зөв нэршлийг сонгоно уу.



A. ухам хутга
B. цүүц хэлбэрийн хутга
C. сам хутга
D. үндсэн зориулалтын хутга

9. Зурагт үзүүлсэн хэлбэрийг ухаж сийлбэрлэхэд хамгийн тохиромжтой хутгыг сонгоно уу.



A. сам хутга
B. цүүц хэлбэрийн хутга
C. ухам хутга
D. үндсэн зориулалтын хутга

10. Зурагт сийлбэрийн ямар багажаар ямар технологи үйл ажиллагаа хийж байна вэ?



A. цүүц хутгаар зорох технологи
B. сам хутгаар засах технологи
C. ухам хутгаар ухах технологи
D. үндсэн зорилтын хутгаар зорох

11. Зурагт ямар төрлийн сийлбэр хийж байна вэ?



- A. цоолбор сийлбэр
- B. хүрээлбэр сийлбэр
- C. бүтэн сийлбэр
- D. хотгор сийлбэр

12. Зурагт үзүүлсэн янгир ямааны сийлбэр ямар төрлийн сийлбэр вэ?



- A. үндсэн материалдаа ухаж сийлсэн ухмал сийлбэр
- B. эвэр, хөлийн зааг байгаа учир цоолбор сийлбэр
- C. янгир ямааны бие товгор байгаа учир товгор сийлбэр
- D. бүтэн биеэрээ харагдаж байгаа тул бүтэн сийлбэр

13. Зурагт үзүүлсэн чимэглэлийн сийлбэр хийхэд ямар ямар багаж хэрэгсэл хэрэгтэй вэ?



- A. үндсэн болон сам хутга, зүлгүүр
- B. ухам хутга, сам хутга, зүлгүүр
- C. цүүц хэлбэртэй хутга, ухам хутга, зүлгүүр
- D. сам хутга, зүлгүүр, цүүц хэлбэртэй хутга

14. Дарханы урлалаар хийсэн хүний толгойн чимэглэл, бугуйвч, дээлийн товч, хормойн боолт, хэт хутга зэргийг ямар эдлэл гэж нэрлэдэг вэ?

- A. гоёл чимэглэлийн эдлэл
- B. бурхан шашны чимэглэл
- C. ахуйн хэрэглээний эдлэл
- D. мал аж ахуйн хэрэглээ

15. Монгол дархчид хэдэн зуун багаж хэрэгсэлтэй байдаг. Дархан хүний хамгийн эрхэмлэдэг ноён гурван багажийг сонгоно уу.

- A. алх, дөш, хайч
- B. алх, хайч, хуурай
- C. алх, хасуур, дөш
- D. алх, хайч, хасуур

16. Монгол дархны урлалд төмөр дээр зэс, гуулийг гагнахгүйгээр ховилдож суулгах технологийг хэрэглэж ирсэн. Энэ технологийг юу гэж нэрлэдэг вэ?



- A. жийжүүдэх
- B. гагнах
- C. шавандах
- D. ширээх

17. Зурагт хөөмөл хийж байгаа үйл явцыг харуулжээ. Сумаар заасан хэрэгслийн нэр болон зориулалтыг сонгоно уу.



- A. бэлдэц бэхлэх лав
- B. ажлын тавцан бэлдэц тавих
- C. бэлдэц наах баримлын шавар
- D. хөөмөл хийх тавцан

18. Хөөмлийг харагдах хэлбэр, хийх технологиор нь ингэмэл хөөмөл, товгор хөөмөл, бүтэн хөөмөл гэж ангилдаг. Зурагт үзүүлсэн товгор хөөмөл хийх технологи үйл ажиллагаанд сумаар заасан хэсгүүд ямар технологи вэ?



- A. товойсон хэсгийн ирмэг тодотгох
- B. нарийн зураас гаргаж цохих
- C. товгор сийлбэрийг үндсэн технологи товойлгох
- D. суурь хэсгийг цоохорлох технологи

19. Усан онгоц нь далбаатай болсноор салхины хүчээр хурдан явах болсон усан онгоцны хөгжлийн нэг том хэсэг юм. Яагаад далбаат усан онгоц ийм олон далбаатай байдаг вэ?



- A. салхины чиглэлээс хамаарахгүй явах
- B. усан онгоц аль болох хурдан явах
- C. усан онгоцны хэлбэр дүрсээс шалтгаалах
- D. салхитай үед сүрлэг харагдах

20. Салхины энергийг ашиглан цахилгаан энерги гаргаж авах нь байгальд ээлтэй цахилгааны эх үүсвэр юм. Нэг төрлийн энергийг өөр төрлийн энерги болгон хувиргах зориулалттай салхин сэнсэнд ашигладаг хөдөлгүүр, генераторыг машин гэнэ.



- A. энергийн
- B. мэдээллийн
- C. кибернетик
- D. ажлын